



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 94

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын Ерөнхий Прокурорын газар, хөдөө орон нутгийн прокурорын газруудын албан ажлын хэрэгцээнд зориулан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд 1,950,400,000.00 (нэг тэрбум есөн зуун тавин сая дөрвөн зуун мянган) төгрөгт багтаан 30 ширхэг автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Улсын Ерөнхий Прокурорын газрын Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Тамгын газрын дарга Ц.Арвинбуудайд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000191

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн
84 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗРЫН ХУДАЛДАН АВАХ АВТОМАШИНЫ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ ҮНИЙН ДЭЭД ХЯЗГААР

Д.д	Автомашины техникийн үзүүлэлт	Тоо ширхэг	Худалдан авах хөрөнгийн үнийн дээд хязгаар	
			Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
			(төгрөг)	
1	Суудлийн тоо 12, хөдөлгүүрийн багтаамж 2400 см.куб	1	86,000,000.00	86,000,000.00
2	Суудлийн тоо 9, хөдөлгүүрийн багтаамж 4164 см.куб	2	117,000,000.00	234,000,000.00
3	Суудлийн тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 1995-2000 Сс	2	94,500,000.00	189,000,000.00
4	Суудлийн тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 3000 Сс	3	94,500,000.00	283,500,000.00
5	Суудлийн тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 1998 см.куб	21	53,900,000.00	1,131,900,000.00
6	Суудлийн тоо 3, хөдөлгүүрийн багтаамж 3900 Сс	1	26,000,000.00	26,000,000.00
НИЙТ ДҮН			471,900,000.00	1,950,400,000.00
			(дөрвөн зуун далан нэгэн сая есөн зуун мянган)	(нэг тэрбум есөн зуун тавин сая дөрвөн зуун мянган)